

СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ БАРУУН-УРТ НИСЭХ БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ДОТООД АУДИТ, ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТОВЧ ТАЙЛАН

2020.10.07

Баруун-Урт сум
7 дугаар баг

ИНЕГ-ын даргын баталсан 2020 оны 07 дугаар сарын 22-ны өдрийн ИНЕГ-ын харьяа Сүхбаатар аймаг дахь Баруун-Урт нисэх буудлын үйл ажиллагаанд дотоод аудит, хяналт шалгалт хийх тухай 26/20 тоот удирдамжийн хүрээнд дотоод аудит, хяналт шалгалтыг хийлээ.

Батлагдсан удирдамжийн дагуу ИНЕГ-ын ДАА-ны ахлах аудитор Л.Жаргалсайхан, санхүүгийн хяналтын мэргэжилтэн Б.Болормаа нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг 2020 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс 2020 оны 10 дугаар сарын 06-ны өдрийг дуустал хугацаанд дотоод аудитыг хийсэн.

ИНЕГ-ын даргын баталсан удирдамжийн хүрээнд Сүхбаатар аймаг дахь Баруун-Урт нисэх буудлын 2018 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс 2020 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийг дуустал хугацааны үйл ажиллагаанд мөрдөгдөж буй дүрэм, журам болон дээд байгууллагаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт, нягтлан бодох бүртгэл, цалин хөлсний бодолт, олголт, төсөв гүйцэтгэл, дотоод хяналт, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орон тооны бус багийн үйл ажиллагаа, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт зэргийг үндсэн баримт нотолгоонд тулгуурлан шалгах, зарим эргэлзээтэй зүйлүүд дээр холбогдох албан тушаалтнаас тайлбар, тодруулга авч ажиллалаа.

Орон нутгийн нисэх буудлуудын 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүнг дүгнэн хэлэлцээд Сүхбаатар аймаг дахь нисэх буудлыг “Оны тэргүүний нисэх буудал”-аар шалгаруулж өргөмжлөл олгосон байна.

Нисэх буудлын 2018 он, 2019 оны санхүүгийн тайланд Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газраас аудит хийж “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргажээ.

Цалин хөлс, түүнтэй адилтгах бусад мөнгөн тооцоо, удаан жилийн нэмэгдэл олголтын тооцоог шалгаж үзэхэд зөрчил гараагүй. Татвар, шимтгэлийн тайланг хуулийн хугацаанд тооцоо нийлж баталгаажуулсан.

Дизель генераторуудын ажиллагаа болон бүртгэл хөтлөлт жигдэрсэн, тухайн сард ажилласан мото/цагийн заалттай тулгасны үндсэн дээр шатахууны тооцоог хийж байна. Цахилгаан тасарсан үед аймгийн эрчим хүчний газраас тухай бүр тодорхойлолт авч хэвшжээ. Түлш, шатахууны тооллогоор тооллогоор зөрчил илрээгүй.

Автомашин хувийн хэргийн болон дизель генераторуудын хувийн хэргийн бүртгэл, хөтлөлт сайн байна.

Хөдөлмөрийн гэрээний нэмэлт өөрчлөлтийг тухай бүр хийгээгүй, нийгмийн даатгалын дэвтэрт ажилд орсон тушаалыг бичээгүй, ажилчдын хувийн хэргийн баяжилт хангалтгүй байна.

Тушаалын үндэслэл хэсэгт хууль, дүрэм журмын заалтыг буруу бичих, дотоод журамд байхгүй заалтыг үндэслэх зэрэг зөрчлүүд нийтлэг байна.

Явуулсан албан бичгийн тэргүүг хэвлэмэл хуудсанд тавьсан тэмдэглэгээнд багтааж, стандартын дагуу бичигдээгүй, тэмдэглэгээний дээр бичигдсэн эсвэл тэмдэглэгээнээс илүү гарган бичсэн мөн төрийг албан хэрэг хөтлөлтийн 2.4 дүгээр зүйлийг мөрдөж ажиллаагүй байна.

Бараа материалын агуулахын эмх цэгц, хадгалалт хамгаалалт, хаягжуулалт хангалтгүй, бараа, материалын хөдөлгөөн, үлдэгдлийн тоо хэмжээг агуулахын дэлгэрэнгүй бүртгэлийн дэвтэрт бүртгээгүй байна.

Нягтлан бодох бүртгэлийн програмд бараа материалын бүлгийг буруу сонгосон.

Дотоод хяналтын багаас хяналт шалгалт хийхдээ удирдамж батлуулаагүй, тайлан бичээгүй, илэрсэн асуудлыг дүгнээгүй, зөвлөмжийн хэрэгжилтийг гаргаагүй байна.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орон тооны бус зөвлөл ажлын төлөвлөгөө, үүрэг даалгаврын төлөвлөгөө гаргаж ажиллаж байгаа хэдий ч хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцах тогтолцоог бэхжүүлж, хяналтын үр нөлөөтэй арга, хэлбэрийг төлөвшүүлэх талаар санаачилга гаргаж ажиллах хэрэгтэй байна.

Галын бүлгэмийг тушаалаар албажуулж томилоогүй, үзлэг шалгалтын эргэн хяналтыг хийдэггүй.

Шилэн дансны мэдээллийг хуулийн хугацаа хоцроож мэдээлж байсан дутагдлаа зассан байгаа хэдий ч мэдээллийг буруу оруулах зөрчил давтагдсаар байна.

Шилэн дансны мэдээлэл, зарлагын гүйлгээ бүрд түүнд холбогдох эрх бүхий этгээдийн шийдвэрийн эх хуулбарыг хавсаргаагүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.10 дахь заалтыг зөрчсөн байна. Мөн <<Төрийн өмчийн аж ахуйн нэгж байгууллагын зорилтот түвшин, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, тайлбарын хамт мэдээлэх>>, <<Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт>> зэрэг талбарууд дээр гүйцэтгэлийн дүнг мянгачилах, дүнг буруу мэдээлэх зэрэг зөрчил илэрсэн.

Аудитын шалтгалтын үр дүнд гарсан алдаа, дутагдлын засаж, залруулах талаар тус нисэх буудалд 12 зөвлөмж өгсөн болно.

ДОТООД АУДИТЫН АЛБА